



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ
АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2006 ОНД ЭЗЭМШҮҮЛЖ, АШИГЛУУЛЖ, ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН
ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

2006 оны 01 сарын 12 өдөр Дархан

Дугаар 03

Монгол улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дугаар заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дархан-Уул аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагад өмчлүүлж, эзэмшүүлэх, ашиглуулах газрын хэмжээг сум тус бүрээр тогтоон нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Аймгийн газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллыг шинэчлэн тогтоох ажлын зардлыг хоёрдугаар хавсралтаар баталж, газрын дуудлага худалдааны орлогоос гаргахыг аймгийн Засаг дарга /Д.Хаянхярваа/-д зөвшөөрсүгэй.
3. Аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрыг өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Хаянхярваа/-д үүрэг болгосугай.

ДАРГА Л.ГҮНЧИН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Р.ТУНГАЛАГ-ЭРДЭНЭ